



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн “Чандмань илч” ОНӨХХК-ийн
2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДГА-2025/01/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас:

www.audit.mn

Дорноговь аймаг

Сайншанд сум

2025 он

Дарга, тэргүүлэх аудитор:

Утас: 70522734

Аудитын менежер:

Утас: 70523020

Аудитор:

Т.Ган-Өлзий

Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn

У.Оюунтүлхүүр

Цахим хаяг: oyuntulkuur.u@audit.gov.mn

Б.Ариунбаатар

Цахим хаяг: ariunbaatarb@audit.gov.mn

Н.Түвшинбаатар

Цахим хаяг: tuvshinbaatar.n@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гуудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (976) 7052 2734
Цахим хуудас: dornogovi@audit.gov.mn

Аудит: 03.14 № 1-6/2024

танай _____-ны № _____-т

ЧАНДМАНЬ-ИЛЧ ОНӨХХК-ИЙН
ЗАХИРАЛ Д.ТӨМӨРБААТАР
ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "Чандмань-Илч" ОНӨХХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант хугацаанд тус байгууллагын үйл ажиллагаанд асуудлыг онцолсон хэсэгт дурдах асуудал илрээгүй болно.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

1. Шинэ жилийн баярыг тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбоотойгоор байгууллагын төсвөөс 1,896.5 мянган төгрөгөөр оргилуун дарс, вино зэргийг худалдан авсан байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.7-д "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд нь байгууллагын төсвөөр согтууруулах ундаа худалдан авахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй байна.

2. Тус байгууллага нь тайлант хугацаанд хөрөнгө зарцуулах нийт 534,566,698 төгрөгийн 58 тушаал шийдвэрээс 411,917,168 төгрөгийн 30 тушаалыг мэдээлээгүй, 122,649,530 төгрөгийн 28 тушаалыг хугацаа хоцроож байршуулсан байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай

442507134

мэдээлдэг байх”, 6 дугаар зүйлийн 6.4.5-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийг долоо хоногийн дотор мэдээлнэ” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3. Тайлант хугацаанд алба, салбаруудын үндсэн чиг үүргээ хэрэгжүүлсэнтэй холбоотой 13.6 сая төгрөгийн урамшууллыг, шинэ жилийн арга хэмжээг тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбоотой ажилчдыг шагнахад 40.8 сая төгрөг, сугалааны хонжворын үйл ажиллагаа зохион байгуулж 2.6 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд нь хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгохыг хориглоно” гэж заасантай нийцэхгүй байна.

4. 2023.11.13-ны өдрийн 136/ШШ2023/00524 дугаар шүүгчийн захирамжаар Ш.Цэрэннадмидыг хууль бусаар ажлаас халсан тогтоогдож ажилгүй байсан хугацааны цалинг гаргуулахаар шийдвэрлэсэн ба 2024 оны 2 дугаар сард тус захирамжийн хэрэгжилтийг хангаж ажилгүй байсан хугацааны цалин 10,500,000 төгрөгийг байгууллагын төсвөөс олгож буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлээгүй байна. Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-д “Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ”, Төрийн албаны тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1-т “Иргэнийг, эсхүл улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагчийг төрийн албанд хууль бусаар томилсон, чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсныг төрийн албаны төв байгууллага, эсхүл шүүх тогтоосон бол төрд учруулсан хохирлыг уг шийдвэрийг гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлнэ” гэж заасантай нийцэхгүй байна.

5. Шинэ жилийн баярын урлагийн арга хэмжээнд 2,720.0 мянган төгрөгийг зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хууль 24 дүгээр зүйлийн 24.7-д “Төсвийн хөрөнгө, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрд болон орон нутагт ногдох хөрөнгийг Нийтээр тэмдэглэх баяр болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 3.1.2-т заасан нийтээр тэмдэглэх тэмдэглэлт өдөр, тэдгээртэй адилтгах аливаа өдөрлөгт зориулж зарцуулахыг хориглоно” гэж заасантай нийцэхгүй байна.

6. Өмнөх оны аудитаар худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй 71,400.0 мянган төгрөгийн “Нарны станцын систем угсралт суурилуулалт”-ын ажлыг хийхдээ ТБОНӨХБАҮХА тухай хуулийн холбогдох заалтыг мөрдөж ажиллаагүй албан шаардлага хүргүүлсэн ба албан шаардлагын хэрэгжилтийг тогтоосон хугацаанд ирүүлж ажиллаагүй байна. Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.4-т “шалгагдагч этгээд болон аудитад хамрагдагч нь төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд шаардсан мэдээлэл, баримт бичгийг бүрэн ирүүлэх үүрэгтэй” гэж заасантай нийцэхгүй байна.

7. Тайлант хугацаанд зорилтот түвшинд тодотгол хийгээгүй ба батлагдсан төсвийг нийт 11,462.7 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна. Тухайлбал, үндсэн түүхий эд материалыг 296.0 сая төгрөгөөр, тээврийн зардлыг 281.1 сая төгрөгөөр, засвар үйлчилгээний зардлыг 782.0 сая төгрөгөөр тус тус хэтрүүлэн зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэхдээ төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэж заасантай нийцэхгүй байна.

Бусад асуудал

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.ГАН-ӨЛЗИЙ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	Үлдэгдэл	
		2024 оны 1 сарын 1	2024 оны 12 сарын 31
1.1.01	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	834,888,852.14	824,159,661.85
1.1.02	Дансны авлага	1,093,874,917.02	1,229,088,917.59
1.1.03	Татвар, НДШ-ийн авлага	-	904,670.00
1.1.04	Бусад авлага	18,285,813.12	193,085,380.70
1.1.06	Бараа материал	1,014,121,899.16	2,043,585,547.27
1.1.07	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	10,400,537,184.10	2,265,939,202.24
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	13,361,708,665.54	6,556,763,379.65
1.2.01	Үндсэн хөрөнгө	30,323,939,084.45	49,453,904,510.19
1.2.02	Биет бус хөрөнгө	2,630,538,917.36	2,626,474,865.79
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	32,954,478,001.81	52,080,379,375.98
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	46,316,186,667.35	58,637,142,755.63
2.1.1.01	Дансны өглөг	1,017,705,379.10	2,353,675,224.97
2.1.1.02	Цалингийн өглөг	-	471,661,750.00
2.1.1.03	Татварын өр	144,408,863.30	1,303,032,568.50
2.1.1.04	НДШ - ийн өглөг	87,945,374.37	184,976,226.38
2.1.1.05	Богино хугацаат зээл	999,998,612.59	-
2.1.1.08	Урьдчилж орсон орлого	10,380,585,585.92	1,263,751,863.26
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	12,630,643,815.28	5,577,097,633.11
2.1.2.01	Урт хугацаат зээл	1,918,465,293.49	1,918,465,293.49
2.1.2.04	Бусад урт хугацаат өр төлбөр	17,987,970,279.45	38,564,024,425.18
2.1.2.06	Урт хугацаат өр төлбөрийн дүн	19,906,435,572.94	40,482,489,718.67
2.2	Өр төлбөрийн нийт дүн	32,537,079,388.22	46,059,587,351.78
2.3.01	Өмч: - төрийн	15,459,856,685.46	15,459,856,685.46
2.3.06	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	7,388,629,707.44	7,388,629,707.44
2.3.08	Эздийн өмчийн бусад хэсэг	521,700,701.20	521,700,701.20
2.3.09	Хуримтлагдсан ашиг	(9,591,079,814.97)	(10,792,631,690.25)
2.3.09.1	Тайлангийн үеийн ашиг	-	(1,201,551,875.28)
2.3.09.2	Өмнөх үеийн ашиг	(9,591,079,814.97)	(9,591,079,814.97)
2.3.11	Эздийн өмчийн дүн	13,779,107,279.13	12,577,555,403.85
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	46,316,186,667.35	58,637,142,755.63

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
1	Борлуулалтын орлого (цэвэр)	11,799,001,183.71	22,867,232,581.52
2	Борлуулалтын өртөг	13,283,729,024.82	27,088,784,313.29
3	Нийт ашиг(алдагдал)	(1,484,727,841.11)	(4,221,551,731.77)
4	Түрээсийн орлого	19,284,727.22	19,602,005.52
5	Хүүний орлого	495,589.18	3,769,148.27
8	Бусад орлого	2,323,516.00	4,530,829,936.44
8.1	Орлогын дүн	22,103,832.40	4,554,201,090.23
9	Борлуулалт, маркетингийн зардал	187,091,884.00	13,933,638.15
10	Ерөнхий ба удирдлагын зардал	890,535,221.86	1,465,199,644.27
12	Бусад зардал	172,971,789.39	48,020,926.31
12.1	Зардлын дүн	1,250,598,895.25	1,527,154,208.73
17	Бусад ашиг (алдагдал)	-	(6,670,110.18)
17.1	Олз, гарзын дүн	-	(6,670,110.18)
18	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	(2,713,222,903.96)	(1,201,275,375.38)
19	Орлогын татварын зардал	-	376,914.83
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(2,713,222,903.96)	(1,201,551,875.28)
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(2,713,222,903.96)	(1,201,551,875.28)

Дорноговь аймгийн “Чандмань-Илч” ХХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын тайлан

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

						/төгрөгөөр/
№	Үзүүлэлт	Өмч	Хөр-н дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2022 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	15,459,856,685.46	7,388,629,707.44	521,700,701.20	-7,758,110,186.73	15,612,076,907.37
2	НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	0.01	0.01
3	Залруулсан үлдэгдэл	-	-	-	-	0.00
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-1,832,969,628.26	-1,832,969,628.26
5	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	0.00
9	2023 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	15,459,856,685.46	7,388,629,707.44	521,700,701.20	-9,591,079,814.98	13,779,107,279.12
10	НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	0.00
11	Залруулсан үлдэгдэл	-	-	-	-	0.00
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	(1,201,551,875.28)	-1,201,551,875.28
13	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	0.00
17	2024 оны 12 сарын 31-р үлдэгдэл	15,459,856,685.46	7,388,629,707.44	521,700,701.20	(10,792,631,690.25)	12,577,555,403.85

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

			/төгрөгөөр/	
Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	18,705,528,705.43	18,833,387,884.10	
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	17,302,933,077.10	16,108,769,788.10	
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	10,079,627.10	-	
1.1.4	Буцаан авсан албан татвар	116,348.00	-	
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	1,308,970,000.00	2,721,292,316.00	
1.1.6	Бусад мөнгөн орлого	83,429,653.23	3,325,780.00	
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	19,315,148,904.43	18,790,387,690.96	
1.2.1	Ажиллагчдад төлсөн	4,560,194,340.58	5,838,404,962.23	
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	1,219,106,485.67	1,793,116,846.50	
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	7,871,354,667.12	5,765,743,935.69	
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	1,775,857,262.03	1,999,936,115.77	
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	1,213,559,667.60	1,481,823,599.59	
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	4,444,302.28	2,500,000.00	
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	1,196,666,225.29	1,156,348,957.61	
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	17,682,885.28	10,092,032.40	
1.2.9	Бусад мөнгөн зарлага	1,456,283,068.58	742,421,241.17	
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(609,620,199.00)	43,000,193.14	
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	2,514,870.15	3,769,148.27	
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	2,514,870.15	3,769,148.27	

Дорноговь аймгийн "Чандмань-Илч" ХХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын тайлан

2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	2,514,870.15	3,769,148.27
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,000,000,000.00	-
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	1,000,000,000.00	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	149,988,916.45	57,498,531.70
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	149,988,916.45	57,498,531.70
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	850,011,083.55	(57,498,531.70)
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	242,905,754.70	(10,729,190.29)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	834,888,852.14	834,888,852.14
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	834,888,852.14	824,159,661.85

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

д/д	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2024		Зөрүү	
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	хувь
1	Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, түгээлт, борлуулалт: Дулаан үйлдвэрлэлт	Гкал	107,800.00	103,195.00	4,605.00	123%
	Цэвэр ус олборлолт	м3	740,000.00	740,512.00	-512.00	113%
	Бохир ус татан зайлуулалт	м3	539,250.00	583,282.00	-44,032.00	113%
2	Нийт орлого	төгрөг	13,944,554,550.00	27,561,832,628.72	-13,617,278,078.72	115%
	Үүнээс: Цэвэр борлуулалт	төгрөг	13,674,014,560.00	14,045,484,900.00	-371,470,340.00	108%
	Бусад орлого /алданги торгуулийн засвар үйлчилгээний орлогууд/	төгрөг	270,539,990.00	13,516,347,100.00	-13,245,807,110.00	199%
3	Нийт зардал	төгрөг	17,300,913,360.00	28,763,653,800.00	-11,462,740,440.00	100%
	Үүнээс: Удирдлагын зардал	төгрөг	890,535,221.86	1,465,199,644.27	-574,664,422.41	100%
4	Татварын өмнөх ашиг /алдагдал/	төгрөг	-3,356,358,810.00	-1,201,821,171.28	-2,154,537,638.72	52%
5	Улсын төсвийн татаас	төгрөг	0	0	0.00	-
6	Цэвэр ашиг, алдагдал	төгрөг	-3,356,358,810.00	-1,201,821,171.28	-2,154,537,638.72	52%
7	Төсвийн төлбөрт нийт дүн	төгрөг			0.00	-
8	Төрийн өмчийн ногдол ашигт	төгрөг		0	0.00	-
9	Нийт ажиллагсдын тоо	хүн	363	317	46.00	83%
10	Нийт цалингийн сан	төгрөг	8,651,343,370.00	8,461,659,600.00	189,683,770.00	86%
11	Нэг ажиллагчийн дундаж цалин	төгрөг	1,901,239.00	2,439,560.00	-538,321.00	110%
12	Нэгж бүтээгдэхүүний өртөг-Дулаан	төг/Гкал		138,939.00	-138,939.00	-
	Нэгж бүтээгдэхүүний өртөг-Цэвэр ус	төг/м.куб		8,199.00	-8,199.00	-
	Нэгж бүтээгдэхүүний өртөг-Бохир ус	төг/м.куб		7,569.00	-7,569.00	-
13	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	төгрөг		2.05	-2.05	-
14	Хөрөнгө оруулалт	төгрөг		2,721,292,300.00	-2,721,292,300.00	-
15	Нийт авлага	төгрөг	1,093,874,917.02	1,227,510,080.32	-133,635,163.30	131%
16	Нийт өглөг	төгрөг	1,017,705,379.10	2,353,675,224.97	-1,335,969,845.87	162%
	Үүнээс: Богино хугацаат	төгрөг			0.00	-

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 101.6 сая төгрөгийн 9 алдаа¹, зөрчил илэрснээс аудитын явцад 29.5 сая төгрөгийн 2 алдааг залруулж, 72.1 сая төгрөгийн 7 зөрчилд 1 төлбөрийн акт, 4 албан шаардлага, 1 зөвлөмж, 1 албан тушаалтанд хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлээ.

5.1 Залруулсан алдаа:

1. Ерөнхий журналыг шалгахад 26.2 сая төгрөгийн зардлыг тооцоо үүсгэлгүй шууд зардалд бүртгэснийг залруулсан.
2. Тус байгууллага нь машин тоног төхөөрөмжийн элэгдлийг 3.3 сая төгрөгөөр дутуу бодуулсныг залруулсан.

5.2 Төлбөрийн акт

Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой

Шинэ жилийн баярыг тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбоотойгоор байгууллагын төсвөөс 1,896.5 мянган төгрөгөөр оргилуун дарс, вино зэргийг худалдан авсан байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.7-д “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд нь байгууллагын төсвөөр согтууруулах ундаа худалдан авахыг хориглоно” гэж заасантай нийцэхгүй байна.

5.3 Албан шаардлага

1. Дотоод хяналт, хариуцлагатай холбоотой асуудал

Тус байгууллага нь тайлант хугацаанд хөрөнгө зарцуулах нийт 534,566,698 төгрөгийн 58 тушаал шийдвэрээс 411,917,168 төгрөгийн 30 тушаалыг мэдээлээгүй, 122,649,530 төгрөгийн 28 тушаалыг хугацаа хоцроож байршуулсан байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6 дугаар зүйлийн 6.4.5-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийг долоо хоногийн дотор мэдээлнэ” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

2. Тус байгууллага нь тайлант хугацаанд алба, салбаруудын үндсэн чиг үүргээ хэрэгжүүлсэнтэй холбоотой 13.6 сая төгрөгийн урамшууллыг, шинэ жилийн арга хэмжээг тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбоотой ажилчдыг шагнахад 40.8 сая төгрөг, сугалааны хонжворын үйл ажиллагаа зохион байгуулж 2.6 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд нь хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгохыг хориглоно” гэж заасантай нийцэхгүй байна.

3. 2023.11.13-ны өдрийн 136/ШШ2023/00524 дугаар шүүгчийн захирамжаар Ш.Цэрэннадмидыг хууль бусаар ажлаас халсан тогтоогдож ажилгүй байсан хугацааны цалинг гаргуулахаар шийдвэрлэсэн ба 2024 оны 2 дугаар сард тус захирамжийн хэрэгжилтийг хангаж ажилгүй байсан хугацааны цалин 10,500,000 төгрөгийг байгууллагын төсвөөс олгож буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлээгүй байна. Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-д “Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ”, Төрийн албаны тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1-т “Иргэнийг, эсхүл улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагчийг төрийн албанд хууль бусаар томилсон, чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсныг төрийн албаны төв байгууллага, эсхүл шүүх тогтоосон бол төрд учруулсан хохирлыг уг шийдвэрийг гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлнэ” гэж заасантай нийцэхгүй байна.

4. Шинэ жилийн баярын урлагийн арга хэмжээнд 2,720.0 мянган төгрөгийг зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хууль 24 дүгээр зүйлийн 24.7-д “Төсвийн хөрөнгө, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрд болон орон нутагт ногдох хөрөнгийг Нийтээр тэмдэглэх баяр болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 3.1.2-т заасан нийтээр тэмдэглэх тэмдэглэлт өдөр, тэдгээртэй адилтгах аливаа өдөрлөгт зориулж зарцуулахыг хориглоно” гэж заасантай нийцэхгүй байна.

5. Өмнөх оны аудитаар худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй 71,400.0 мянган төгрөгийн ажлыг хийхдээ ТБОНӨХБАҮХА тухай хуулийн холбогдох заалтыг мөрдөж ажиллаагүй албан шаардлага хүргүүлсэн ба албан шаардлагын хэрэгжилтийг тогтоосон хугацаанд ирүүлж ажиллаагүй байна. Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.4-т “шалгагдагч этгээд болон аудитад хамрагдагч нь төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд шаардсан мэдээлэл, баримт бичгийг бүрэн ирүүлэх үүрэгтэй” гэж заасантай нийцэхгүй байна.

5.4 Зөвлөмж

Тайлант хугацаанд зорилтот түвшинд тодотгол хийгээгүй ба батлагдсан төсвийг нийт 11,462.7 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна. Тухайлбал, үндсэн түүхий эд материалыг 296.0 сая төгрөгөөр, тээврийн зардлыг 281.1 сая төгрөгөөр, засвар үйлчилгээний зардлыг 782.0 сая төгрөгөөр тус тус хэтрүүлэн зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэхдээ төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэж заасантай нийцэхгүй байна.

Үр дагавар: Батлагдсан төсөв үр ашиггүй зарцуулагдах, хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдахгүй байх

Өгсөн зөвлөмж: Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах, батлагдсан төсвийг хэтрүүлэн зарцуулахгүй байх, шаардлагатай тохиолдолд Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар оруулан тодотгох;

Дээрх албан шаардлагын хэрэгжилтийг тогтоосон хугацаанд, зөвлөмжийн хэрэгжилтийг 2025 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
							Залруулсан		Залруулаагүй	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шууд зардалд бүртгэсэн	1	26,198.1	-	-	1	26,198.1	1	26,198.1		
Элэгдэл алдаатай тооцоолсон	1	3,315.2			1	3,315.2	1	3,315.2		
Дүн	2	29,513.3	-	-	2	29,513.3	2	29,513.3		

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Батлагдсан төсвийг хэтрүүлэн зарцуулсан	1	-					1	-				
Үндэслэлгүй ажлаас халсан нь тогтоогдож ажилгүй байсан хугацааны цалинг байгууллагаас төлсөн	1	10,500.0			1	10,500.0						
Төсвийн хөрөнгөөр согтууруулах ундаа худалдан авсан	1	1,896.5	1	1,896.5								
Шинэ жилийн баярын урлагийн арга хэмжээнд байгууллагын төсвөөс зарцуулсан	1	2,720.0			1	2,720.0						
Өмнөх оны албан шаардлагын хэрэгжилт ирүүлээгүй	1	-							1	1		
Дүн	5	15,116.5	1	1,896.5	2	13,220.0	1	-	1	1		

Дорноговь аймгийн “Чандмань-Илч” ХХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил										
Шилэн дансны мэдээлэл системд байршуулаагүй	1	-			1	-				
Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллаагүй	1	56,965.0			1	56,965.0				
Дүн	2	56,965.0			2	56,965.0				
Нийт дүн	7	72,081.5	1	1,896.5	4	70,185.0	1	-	1	1

Дорноговь аймгийн “Чандмань-Илч” ХХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын тайлан